

Батлав.  
БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчны  
бодлого зохицуулалтын газрын дарга

Г.Энхмөнх

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:  
“Маргад” жуулчны баазын захирал

П.Эрхэмбаяр

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН НУТАГ ДЭВСГЭР ХӨВСГӨЛИЙН БЦГ-ЫН  
ЖАНХАЙН АРДАГИЙН АМ НЭРТЭЙ ГАЗАРТ БАЙРЛАХ “МАРГАД” ЖУУЛЧНЫ БААЗЫН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР РА97012017/

Хянасан:  
БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин,  
Байгалийн Нөөцийн Удирдлагын газрын мэргэжилтэн

Боловсруулсан:

“Маргад” жуулчны баазын менежер

Б.Даваахүү

### 1. Төслийн товч танилцуулга

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/618 дугаар журам “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах тайлагнах журам”-ын дагуу дараах ажлуудыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

**Төслийн нэр:** “Маргад” жуулчны бааз

**Төсөл хэрэгжүүлэгч:** “Маргад” жуулчны бааз иргэн П.Эрхэмбаяр

Регистрийн дугаар: РА97012017

Хаяг, байршил: Хөвсгөл Алаг эрдэнэ сум Хатгал тосгоны 6-р баг Ардагийн ам

Захирал: П.Эрхэмбаяр

Утасны дугаар: 99383080, 88013740

**Төслийн үргэлжлэх хугацаа:** 2015 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж байна.

**Төслийн зорилго:** Экологи, газар зүйн хувьд онцгой ач холбогдолтой байгалийн аялал жуулчлалын томоохон бүс болох Хөвсгөлийн БЦГ-ыг түшиглэн гадаад, дотоодын аялагч жуулчдын амрах таатай орчныг бүрдүүлэх, экосистемийг сурталчлан таниулах, үндэсний болон олон улсын түвшинд нийцсэн, нийгэм эдийн засгийн хувьд үр өгөөжтэй үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд уг төслийн гол зорилго оршино.

**Төслийн үндэслэл:** Маргад амралтын газар нь 2020 оны 07 дугаар сарын 02 өдрийн А/534 тушаалаар Хөвсгөл аймгийн Алаг эрдэнэ сумын нутаг Хөвсгөлийн БЦГ нутгийн Жанхайн ардагийн ам нэртэй газарт 8816 м<sup>2</sup> газрыг Аялал жуулчлалын зориулалтаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас газар ашиглах гэрчилгээ авсан.

Мөн дотоодын аялал жуулчлалын үзэсгэлэн яармагт жил бүр оролцон, жилээс жилд өөрийн гадаад харилцаагаа өргөжүүлсээр ирсэн. 2015 оноос гэр буудал, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж ирсэн туршлагатай.

**Төсөл хэрэгжиж буй талбайн байршил:**

Маргад жуулчны бааз нь Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын нутаг дэвсгэр, Жанхайн Ардагийн ам нэртэй 8839 м<sup>2</sup> га газарт байршина.

Хүснэгт 1 Маргад жуулчны баазын байршил

№	Хойд өргөрөг	Зүүн уртраг	Нийт талбайн хэмжээ
1	50 37 39.98	100 11 48.15	8816 м <sup>2</sup>
2	50 37 38.82	100 11 43.05	
3	50 37 40.67	100 11 41.36	
4	50 37 42.68	100 11 47.22	

**2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга:**

Манай амралтын газар нь аялал жуулчлалын үйл ажиллагааны чиглэлээр доорх үйлчилгээнүүдийг дотоодын аялагч, жуулчдад үзүүлж байна. Үүнд: амрагчдын том жижиг байр снукер биллиард , ширээний теннис, сагсан бөмбөг, гар бөмбөг, агаарын теннис, амрагчдыг чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх орчныг бүрдүүлсэн.

Дотоод гадаадын амрагч нарыг таатай орчныг бүрдүүлэх, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл цэвэр орчинд үйлчилнэ. Нэг удаад 50-80 хүлээн авах хүчин чадалтай байшин буудал-9, гэр буудал-9, автомашины зогсоол, сүүдрэвч, тоглоомын талбай, ногоон байгууламж зэргийг зураг төслийн дагуу баригдахаар төлөвлөгдсөн байна.

*Зураг 1. Маргад жуулчны баазын харагдах байдал*





Хөвсгөл аймаг нь нийт 132146 хүн амтай, тэдгээрийн 39404 нь аймгийн төв Мөрөн суманд, 3195 нь Хатгал тосгонд, 24844 нь сумын төвд, 64736 нь хөдөө оршин суудаг. 2017 оны Боловсруулсан: “Маргад” жуулчны бааз

байдлаар нийт хүн амын 65588 хүн буюу 49.6 хувь нь эрэгтэй, 66558 хүн буюу 50.4 хувь нь эмэгтэй хүн ам байна. Хөвсгөл аймагт оршин сууж байгаа 132146 хүн ам нь Монгол улсын нийт хүн амын 4.2 хувийг эзэлж байна.

Хөвсгөл аймаг нь нийт 23 сум, 124 баг, 1 тосгонтой. Нийт 38746 өрхийн 132146 хүн амтай. Аймгийн төв Мөрөн сум бөгөөд Улаанбаатар хотоос 779 километр зайтай оршдог. Анх 1809 онд “Мөрөнгийн хүрээ”-ий суурь тавигдаж, 1811 онд баригдсанаар түүний эргэн тойрон нүүдэллэн суух хүмүүсийн тоо нэмэгдсээр сумын суурь үүссэн түүхтэй. 1931 оноос Мөрөн сум хэмээн нэрлэгдэх болж, улмаар 1933 онд Хөвсгөл аймгийн төвийг Хатгалаас Мөрөн лүү шилжүүлэх тушаал гарснаар Мөрөн сум аймгийн төв болсон.

### 3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Нөлөөлөлд өртөгч	Газрын гадарга, хэвлий		Агаарын чанар		Хөрсөн бүрхэвч		Ургамлан нөмрөг		Амьтны аймаг		Газрын доорх ус		Хүн амын эрүүл мэнд		Дүн	
	Нөлөөлөгч															
Хатуу хаягдал хог	3	3	5	6	7	6	7	6	4	3	4	5	7	5	37	34
Шингэн хаягдал хог	3	3	5	6	7	6	7	6	4	3	6	6	7	5	39	35
Дуу чимээ, шуугиан	1	1	5	6	1	1	1	1	5	5	1	1	7	8	21	23
Тээврийн хэрэгсэл (утаа, тоосжилт)	5	5	6	6	5	4	5	4	4	3	2	1	5	6	32	29
Дэд бүтэц /авто зам, шугам хоолой, хашаа, тоглоомын талбай г.м/	2	3	6	7	5	6	5	6	4	5	1	1	6	7	29	35
Барилга байгууламж /төслийн төлөвлөлт/	4	5	4	3	5	6	5	6	4	3	1	1	4	3	27	27
<b>Дүн</b>	<b>18</b>	<b>20</b>	<b>31</b>	<b>34</b>	<b>30</b>	<b>29</b>	<b>30</b>	<b>29</b>	<b>25</b>	<b>22</b>	<b>15</b>	<b>15</b>	<b>36</b>	<b>34</b>	<b>185</b>	<b>183</b>

Үнэлгээний хүснэгтийн босоо багануудын нийлбэр дүнгээс үзвэл, төслийн үндсэн үйл ажиллагаа болох барилга байгууламж, дэд бүтэц, тээврийн хэрэгсэл зэрэг нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл их байна. Хэвтээ багануудын нийлбэр дүнгээс үзвэл агаар, хөрс, ургамал зэрэг нь хамгийн их өртөгч байна.

Матрицын аргаар үнэлсэн дүнгээс авч үзэхэд үнэлгээний нийт оноо 185 байгаагаас Хатуу хог хаягдал 37 буюу 20%, шингэн хог хаягдал 39 буюу 21%, дуу чимээ, шуугиан 21 буюу 11,3%, тээврийн хэрэгсэл 32 буюу 17,2%, тоосжилт 29 буюу 15,6%, бараа бүтээгдэхүүн ачиж буулгах 27 буюу 14,5% байна. Нөлөөллийн эрчмийн хувьд тээврийн хэрэгсэл, хог хаягдал илүү эрчимтэй байхаар байна.

Байгалийн бүрэлдэхүүн хэсэг болох хөрсөн бүрхэвчинд 16,2%, агаарын чанарт 16,7%, ургамлан нөмрөгт 16,2%, хүний эрүүл мэндэд 19,4% сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна.

#### **Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй нөлөөлөл**

- ✓ Барилга угсралтын үеийн хөрс хуулалтаас үүсэх тоосжилт
- ✓ Ачаа тээвэрлэлтийн үед хүнд даацын машин механизмын хөдөлгөөний улмаас үүсэх тоосжилт
- ✓ Машин механизмуудын түлшний шаталтаас гарах хорт хий /азотын давхар исэл, хүхэрлэг хий/
- ✓ Дуу шуугиан болон цахилгаан соронзон долгионы нөлөөлөл
- ✓ Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хатуу, шингэн хог хаягдал
- ✓ Байгалийн хүчин зүйл /шороон шуурга/ болон төслийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт мөн утаа зэргээс хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй

Аялал жуулчлалын бааз төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх гол нөлөөллүүд нь барилгажилтын үеийн тээвэрлэлтээс үүсэх тоосжилт, дуу чимээ, хог хаягдал болон тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагаатай шууд хамааралтай.

#### **Хөрсөн бүрхэвчид үзүүлэх гол болон болзошгүй нөлөөлөл**

- ✓ Барилга байгууламжуудыг барих, өргөтгөх явцад түүний ойр орчмын талбайн хөрсөн бүрхэвч талхлагдах, шинээр олон салаа замууд үүсэх;
- ✓ Овор ихтэй хүнд ачаан (барилгын материал) доор удаан байсан хөрс дагтарших
- ✓ Амрагч жуулчдын тоо олширч түүнийгээ даган тээврийн хэрэгсэл ихэссэнээр зам жим олширч хөрсний элэгдэл ихсэх
- ✓ Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас мөн хүний санамсаргүй үйл ажиллагаанаас шалтгаалан ямар нэгэн шатах, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсийг бохирдуулах
- ✓ Төслийн ойр орчимд хүний үйл ажиллагаатай холбоотойгоор хог хаягдал бий болж ойр орчмын хөрсийг бохирдуулах

Аялал жуулчлалын бааз төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд үзүүлэх гол нөлөөллүүд нь барилга байгууламж барих үйл явц, хог хаягдал, амрагчдын болон тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагаатай шууд хамааралтай.

#### **Ургамлан нөмрөгт үзүүлэх гол болон болзошгүй нөлөөлөл**

- ✓ Барилга байгууламжуудыг барих, өргөтгөх явцад түүний орчмын талбайн ургамлан нөмрөг талхлагдах, устгах
- ✓ Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас олон салаа замууд үүсэж ургамлан нөмрөг талхлагдах
- ✓ Овор ихтэй хүнд ачаан (барилгын материал) доор удаан байсан ургамлан нөмрөг устгах, дагтарших
- ✓ Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хатуу, шингэн хог хаягдлын нөлөөгөөр ургамлан нөмрөг хордох, устгах
- ✓ Тоосжилтын нөлөөгөөр ургамлын морфологид өөрчлөлт орж, фотосинтезийн эрчим буурч болзошгүй.
- ✓ Хуурайшилт ихтэй үед ажилчдын анхаарал болгоомжгүй байдлаас хээрийн түймэр гарч болзошгүй

#### **4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилго, зорилт хамрах хүрээ**

Боловсруулсан: “Маргад” жуулчны бааз

Аялал жуулчлалын бааз төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)ний зорилго нь төслийн бүхий л үе шатанд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар төсөл хэрэгжүүлэгч энэхүү төлөвлөгөөг дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

БОМТ-ний үндсэн зорилгыг хангахын тулд төсөл хэрэгжүүлэгчийн санхүүгийн чадавхын хүрээнд нийгмийн хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэсэн дараах зорилтыг хангана. Үүнд:

- ✓ БОМТ-нд тусгасан ажлын дараалал, түүнийг хийж гүйцэтгэснээр хүрэх үр дүнг нөхөн сэргээлтэд тавих шаардлагын хэмжээнд хүргэх;
- ✓ БОМТ-ний хэрэгжилтийг төсөл хэрэгжүүлэгч өөрөө болон орон нутгийн оршин суугчдын зүгээс хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүнд хүрэх;
- ✓ БОМТ-г зохих ёсоор хэрэгжүүлснээр төсөл хэрэгжүүлэгчийг хөндлөнгийн хяналт, шалгалтад бэлэн байлгах нөхцөлийг бүрдүүлнэ.

БОМТ нь төслийн үйл ажиллагааны цар хүрээнд байгаль орчин, нийгмийн хамгааллын дараах асуудлыг хамарч, хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөнө. Үүнд:

- ✓ Төслийн хүрээнд бий болох сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, холбогдох зардлыг тооцох;
- ✓ Нөхөн сэргээх, нөхөн хамгаалах ажлыг төлөвлөж, зардлыг тооцох;
- ✓ Түр нүүлгэн шилжүүлэлт хийх ажлын дэс дараалал, зохион байгуулалт, холбогдох зардлыг тооцох;
- ✓ Осол, эрсдэл, аюултай нөхцөл байдлын үед хүний эрүүл мэнд болон хүрээлэн буй орчныг хамгаалах бодлогыг тодорхойлох;
- ✓ Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх арга замыг зааж, холбогдох зардлыг тооцох;
- ✓ Нөхөн сэргээлтийн талаарх мэдээллийг олон нийтэд таниулах зэрэг асуудлыг тусгана.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлээгүйгээс байгаль орчинд учирсан хохирлыг арилгах, нөхөн төлбөрийг төлөх үүргийг төсөл хэрэгжүүлэгч хүлээнэ.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалын хавсралт Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 2.1, 2.2, 2.13, 2.14-т заасны дагуу төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж мөн энэхүү журмын 4.1, 4.3-т заасны дагуу биелэлтийн тайланг хүргүүлнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 5 жилээр боловсруулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлын тооцоог зах зээлийн өнөөгийн үнийн дүнгээр тооцов.

*Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын нутаг дэвсгэр, Хөвсгөлийн БЦГ-ын Жанхайн Ардагийн ам нэртэй газарт байрлах “Маргад” аялал жуулчлалын баазын 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

*Хүснэгт 2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардал*

№	Хэрэгжүүлэх хэмжээ	арга	Нийт зардал 5 жилээр, (мян. төг)	2021 он (мян. төг)	2022 он (мян. төг)	2023 он (мян. төг)	2024 он (мян. төг)	2025 он (мян. төг)
1	Сөрөг бууруулах төлөвлөгөө	нөлөөллийг арга хэмжээний	52.484.0	37.784.0	6.592.0	2.036.0	4.036.0	2.036.0
2	Орчны цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	тохижилт	2.500.0		2.500.0			
3	Хог менежментийн төлөвлөгөө	хаягдлын	2.000.0	1.200.0	200.0	200.0	200.0	200.0
4	Орчны шинжилгээний хөтөлбөр	хяналт	1.667.0	333.4	333.4	333.4	333.4	333.4
5	БОМТ-г нөлөөлөлд суугчид, талуудад хуваарь	хэрэгжилтийн өртөгч оршин оролцогч тайлагнах	2.000.0	400.0	400.0	400.0	400.0	400.0
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>			<b>60.651.0</b>	<b>39.717.0</b>	<b>10.025</b>	<b>2.969.0</b>	<b>4.969.0</b>	<b>2.969.0</b>



5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Жуулчны баазын үйл ажиллагааны явцад орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгах, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах бичиг баримт зэргийг байгалийн бүрэлдэхүүн тус бүрээр тодорхойлон доорх хүснэгтэд нэгтгэн үзүүлсэн болно.

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал/төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Жуулчны бааз ашиглалтын явцад машин механизмуудын түлшний шаталтаас гарах хорт хий /азотын давхар исэл, хүхэрлэг хий/, утаа болон цаг агаарын хуурайшилт ихтэй хавар, намрын улиралд төслийн талбай орчмын шороон замаас тоосжилт үүсэх	Жуулчны баазын үйл ажиллагаанаас гарах тоосжилтыг бууруулах, явган зам авто машины зогсоолын тоосжилтыг багасгах зорилгоор усалгаа хийх.	Төслийн талбайн зогсоол болон үүд хэсгийн 1500 м2 талбай	литр	1м3-1267төг 3 м3-3040.8 төг	1м2-2 литр 1500м2*2 л= 3000л	Жилд3 9 удаа*3040.8төг=9122 төг 9122төг*1жил= 9122төг	2 сард 6 удаа	Агаарын тухай хууль, - MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага - Монгол Улсын агаарын чанарын стандарт. MNS 5457: 2005;

Боловсруулсан: “Маргад” жуулчны бааз

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын нутаг дэвсгэр, Хөвсгөлийн БЦГ-ын Жанхайн Ардагийн ам нэртэй газарт байрлах “Маргад” аялал жуулчлалын баазын 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	дуу чимээ, хог хаягдал зэрэг болно								- Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010
2.	Жуулчны баазын үйл ажиллагааны явцад үүсэх хог хаягдлыг зохих ангиллын дагуу ангилж зохих хаягдлын цэгт хаях, шатаахгүй байх	Жуулчны баазаас гарсан хог хаягдлыг ангилан ялгаж Хатгалын нэгдсэн хогийн цэгт тээвэрлэж хүргэх.	Төслөөс гарч буй хатуу бүх төрлийн хог хаягдал	тн	150,000/төгрөг	4 тн	450,000	2 сард 3 удаа	
3.		Жуулчны баазаас гарах бохирыг Хатгал тосгоны Харганы амын цэвэрлэх байгууламж руу зөөвөрлөх	Шингэн хог хаягдал	тн	7тн-50000	17тн	1.050.000	2 сард 3 удаа	
4.	Нийт дүн	1.509.122							

Хүснэгт 2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал/төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Төслийн талбайн 20-с багагүй хувьд	Жуулчны баазын баруун хойд талд ногоон зурвас бий болгох	Мод тарих, зүлэгжүүлэх /Шар хуайс, нарс/	тоо	Шинэс- 20*15000=300.000 Улиас- 20*7000=140.000	40 ширхэг	545000	5-10 саруудад	-Эвдэрсэн газры нөхөн сэргээлт” MNS 5914:2008

Боловсруулсан: “Маргад” жуулчны бааз

	ногоон байгууламж бий болгох		Олон настын үр цацаж ногоон байгууламж бий болгох		Олон настын үр- 3кг*35000=105000					- “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага” MNS 5918:2008  -Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS 6260 : 2011
	Нийт	545000								

Хүснэгт 3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал/ төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ахуйн	Хог хаягдлыг зориулалтын, битүүмжлэлтэй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэх	Хог хаягдал тээвэрлэдэг зориулалтын авто машин жолоочтой гэрээ байгуулж тээвэрлүүлэх.	тн	1тн-150.000	5тн	750.000	2 сард 5 удаа	Хог хаягдлын тухай хууль, 2017 он
2.	Үйлдвэрийн	Хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал	Жуулчны баазын салхинд доод хэсэгт хог хаягдлыг цуглуулах хогийн цэг байгуулах	ширхэг	700,000	1ш	700,000	5 сард	

Боловсруулсан: “Маргад” жуулчны бааз

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын нутаг дэвсгэр, Хөвсгөлийн БЦГ-ын Жанхайн Ардагийн ам нэртэй газарт байрлах “Маргад” аялал жуулчлалын баазын 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн хогийн сав ашиглах								
	Нийт зардал	1.450.000							

Хүснэгт 4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1.	Орчны хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бактерийн тоо	Жуулчны баазын эргэ тойронд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийх	Жуулчны баазын байрууд	М <sup>2</sup>	20,000	4х6-ын дүнзэн байшин	40м2*10,000=400.000	6 сард	- MNS 3298:199 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхи шаардлага
2.	Ундны усыг шинжилгээнд хамруулах	Стандарт хэмжил зүйл газарт усны дээжийг хүргүүлж шинжилгээ хийлгэнэ	Жуулчны бааз	1ш	100,000	1 ширхэг	100,000	6 сард	Усны тухай хуул Ундны усны эрүүл ахуйн шаардлага сана аюулгүй байдлыг үнэлгээний MNS 0900:2018 стандарт
	Нийт	500,000 /мянган төгрөг/							

Боловсруулсан: “Маргад” жуулчны бааз

Байгаль орчны удирдлагын тогтолцооны гол зорилго нь төслөөс байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилан илрүүлж түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах ба хянахад чиглэсэн байх ба байгаль орчны бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт шалгалт хийх, удирдлагын дүн шинжилгээ хийх гэсэн таван үе шаттай хэрэгжүүлэх бөгөөд энэ нь байгаль орчны үзүүлэлтийг тасралтгүй сайжруулах ач холбогдолтой.

Хүснэгт 5. БОМТ-г хэрэгжилтийн нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах

БОМТ, БОМТ хэрэгжилтийг тайлагнах, оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээний агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/	Зохион байгуулах газар
Хөвсгөл нуурын Улсын Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаанд	3-аас доошгүй хэвлэмэл хувь, цахим хэлбэрээр	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан	Жил бүрийн 11 сарын 01	120.0*1 жил=120,0	Маргад жуулчны баазын менежер	Жуулчны баазад
БОАЖЯ-ны ХБОБНГ-т	Хэвлэмэл хэлбэрээр	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан	Жил бүрийн 12 сард	120.0*1 жил=120,0	Маргад жуулчны баазын менежер	БОАЖЯ

Хүснэгт 6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2023 он				
			Сар....	Сар....	Сар.....		
1	2	3	4	5	6	7	
1.	Жуулчны баазын үйл ажиллагаанаас гарах тоосжилтыг бууруулах, явган зам авто машины зогсоолын тоосжилтыг багасгах зорилгоор усалгаа хийх.	9122	5,6,7 сард			Жуулчны баазын хамгаалалтын ажилтан	Хамгаалалтын ажилтан 2 хүн хуваарийн дагуу хийнэ
2.	Жуулчны баазаас гарсан хог хаягдлыг ангилан ялгаж Хатгал тосгоны нэгдсэн хогийн цэгт тээвэрлэж хүргэх.	450.000	7, 8 сард			Гэрээ байгуулсан газар	Хог хаягдал тээвэрлэгч ХХК-тай гэрээ байгуулж тээвэрлүүлэх
3.	Жуулчны баазаас гарах бохирыг Хатгал тосгоны Харганы амын цэвэрлэх байгууламж руу зөөвөрлөх	1050,000	7, 8 сард			Гэрээ байгуулсан газар	Бохир ус тээвэрлэгч иргэн, ААН-тэй гэрээ байгуулж зөөвөрлүүлэх
4.	Жуулчны баазын баруун хойд талд ногоон зурвас бий болгох	545.000	5 сар			Жуулчны баазын бүх ажилчид	Жуулчны баазын бүх ажилтан нийт 10 хүн
5.	Хог хаягдлыг зориулалтын, битүүмжлэлтэй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэх	750,000 мянган төгрөг	7, 8 сард			Гэрээ байгуулсан газрын маяги автомашинаар	Гэрээ байгуулсан аж ахуйн нэгжтэй бүтээлэг битүүмжлэлтэй зориулалтын

Боловсруулсан: “Маргад” жуулчны бааз

					тээврийн хэрэгслээр тээвэрлэх
6.	Хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн хогийн сав ашиглах	700,000	5 сард	Мэргэжлийн ХХК-аар хийлгэх	Жуулчны баазын ажилтан 5 хүн хийнэ
7	Жуулчны баазын эргэн тойронд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийх	400,000	7 сар	“Ган өрлөг” ХХК	Гэрээ байгуулж хийлгэх
8.	Ундны усыг стандарт хэмжил зүйн газрын лабораторт шинжлүүлэх	100,000	7 сар	Стандарт хэмжил зүйн газар лаборатор	Стандарт хэмжил зүйн газар
	Нийт	4.004.122			

Маргад жуулчны баазын 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 14.909.122 төгрөг (арван дөрвөн сая есөн зуун гучин есөн сая нэг зуун хорин хоёр мянган төгрөг) зарцуулагдана.

Хүснэгт 8. 2023 оны БОМТ-нд зарцуулагдах нийт зардал, төгрөг

Д/д	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулга	Нийт зардал, төгрөг
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,509,122
2.	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1.730.000
3.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	10.950.000
5.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	750.000
6.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	120.000
7.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах хуваарь	120.000
	Нийт зардал, төг	14,939,122.00

Тус төслийг хэрэгжүүлэх 1 жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 14.939.122 мян.төгрөгийг төлөвлөж байна.



**Маргад жуулчны баазын 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хавсралтууд:**

**Хавсралт 1. Ариун цэврийн байгууламж**

**Хавсралт 2. БОННУ-ний нүүр**

**Хавсралт 3. 5 жилийн менежментийн төлөвлөгөөний нүүр**

**Хавсралт 4. БОНБЕҮнэлгээний дүгнэлт**

**Хавсралт 5. Газрын кадастр**

### **Хавсралт 1. Ариун цэврийн байгууламж**

Маргад жуулчны бааз нь стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай. Ариун цэврийн байгууламж нь эр эм боловсон ариун цэврийн өрөө, угаалтуур, душ, гар угаах гадаах угаалтуур болон бохирын нөөцийн сав бүхий байгууламжуудаас бүрдэнэ.

Зураг 1. Душны тохижилт



Боловсруулсан: “Маргад” жуулчны бааз

Зураг 2. Бие засах өрөө



Зураг 3. Гадаах угаалтуур



Зураг 4. Бохирын байгууламж гүйцэтгэсэн ажил



Боловсруулсан: “Маргад” жуулчны бааз



Бохирын нөөцийн савыг газар ухаж, бетонон цутгалт хийн халих, хөрс руу орох эрсдэлээс сэргийлэн суулгасан. Цугларсан бохирыг бохир сорох машинаар соруулж зайлуулдаг.

Зураг 5.Бохирыг соруулж буй байдал



**Хавсралт 2. БОННУ-ний нүүр**

**Батлав:**

БОАЖЯ-ны срөнхий шинжээч:

БОАЖЯ-ны шинжээч:



Г.ЭНХМӨНХ

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН НУТАГ ХӨВСГӨЛИЙН  
БЦГ-Т ХЭРЭГЖИХ “МАРГАД” АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БААЗ ТӨСЛИЙН  
БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ  
ТАЙЛАН**

**ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:**

“Эко Ти Эс Би” ХХК-ний захирал



А.САНЖААЖАМЦ

**ТАНИЛЦСАН:**

Иргэн



П.ЭРХЭМБАЯР

Улаанбаатар хот  
2022 он

**Хавсралт 3. 5 жилийн менежментийн төлөвлөгөөний нүүр**

**Батлав:**  
БОАЖЯ-ны ерөнхий шинжээч:



Г.ЭНХМӨНХ

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН НУТАГ ХӨВСГӨЛИЙН  
БЦГ-Т ХЭРЭГЖИХ “МАРГАД” АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БААЗ ТӨСЛИЙН  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ /2022-2026 ОН/**

**ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:**

“Эко Ти Эс Би” ХХК-ний захирал



А.САНЖААЖАМЦ

**ТАНИЛЦСАН:**


Иргэн



П.ЭРХЭМБАЯР

Улаанбаатар хот  
2022 он

**Хавсралт 4. БОНБЕҮнэлгээний дүгнэлт**



"ИРГЭН П.ЭРХЭМБАЯР"-Д

**МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,  
Утас: 26 19 66, Факс: (976-51) 26 61 71,  
E-mail: contact@mne.gov.mn, http://www.mne.mn

2019. 7. 25 № 13/5171

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т


Ерөнхий үнэлгээний дүгнэлт  
хүргүүлэх тухай

Танай байгууллагаас боловсруулж ирүүлсэн Хөвсгөлийн байгалийн цогцолборт газрын "Ардгийн ам" 0.88 га талбайд Аялал жуулчлалын баазын төслийн "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам"-ын 3 дахь хэсгийг үндэслэн, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлалын дагуу ерөнхий үнэлгээ хийлээ.

Ерөнхий үнэлгээний дүнгээр уг төсөлд батлагдсан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэв.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудаст заасан нарийвчилсан үнэлгээний явцад тодруулах асуудлууд, онцгойлон анхаарах чиглэлийг харгалзан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж 2019 оны 4 дүгээр улиралд багтаан тус яаманд ирүүлэхийг үүгээр мэдэгдье.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудсыг хавсаргав.



ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ \_\_\_\_\_ П.ЦОГТСАЙХАН

2019 oni bichig/07.01-09.31/  
024564



**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

**ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУУДАС**

2019 оны 07-р сарын 10

Улаанбаатар хот

Төслийн дугаар

Дугаар 2019/Б-129

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: “Иргэн П.Эрхэмбаяр”, Хөвсгөл, Мөрөн 5-р баг, 28 гудамж 1 тоот.

Холбоо барих утас, и-мэйл хаяг: 976-88007734

Төслийн нэр: Аялал жуулчлалын бааз;

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил: Хөвсгөлийн байгалийн цогцолборт газрын “Ардгийн ам”-д хэргэжинэ;

Холбогдох этгээдийн санал: Алга-Эрдэнэ сумын 2018 оны 04 дүгээр сарын 06-ний 1/157 тоот санал. Хөвсгөлийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2019 оны 04 дүгээр сарын 12-ний өдрийн №68 тоот саналыг үндэслэв.

Ерөнхий үнэлгээний гол шалгуурууд	Нийцсэн	Нарийвчилсан үнэлгээний явцад хууль тогтоомжийн нийцлийг нарийвчлан тодорхойлох			
		Нийцээгүй	Хэсэгчлэн	Хэсэгчлэн	Хэсэгчлэн
Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн нийцэл	Тийм				Нарийвчилсан үнэлгээний явцад хууль тогтоомжийн нийцлийг нарийвчлан тодорхойлох
Төрийн бодлого, шийдвэрийн нийцэл	Тийм				
Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд	Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх (урсац бүрэлдэх эх, ойн болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, хилийн хамгаалалтын бүс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар г.м)			Тийм	
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг, мэдрэмтгий эсэх			Тийм	
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр			Тийм	

	орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн, сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй газар байгаа эсэх				
	Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсгэх эсэх			Тийм	
	<b>Агаарын чанар</b>				
	Бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгаруулах, эсэх			Тийм	
	Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх, эсэх			Тийм	
	1. Төслийн явцад орчны бохирдлыг тооцож, үйл ажиллагаанаас агаарт үзүүлж болзошгүй нөлөөллийг тодорхойлох, 2. Төслийн үйл ажиллагаанаас гарах хатуу, шингэн хог хаягдлын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тогтоож, арилгах, бууруулах, байгаль орчинд халгүй аргаар зайлуулах арга хэмжээг төлөвлөх,				
	<b>Усан орчин</b>				
	Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх, эсэх			Тийм	
	Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх			Тийм	
	Гадаргын болон газрын доорх усанд бохирдол үүсэх, эсэх			Тийм	
	1. Газрын доорхи болон гадаргын усны нөхцөл байдлыг тодорхойлж, төслийн үйл ажиллагааны явцад ашиглах усны эх үүсвэр, хэмжээг тодорхойлж, түүнтэй уялдуулан нарийвчилан тооцох; 2. Төслийн үйл ажиллагаанаас усны нөөц, горим чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоож, түүнд тавих хяналт, хугацаа, хөрөнгө зардлыг нарийвчилан тооцох; 3. Усны алдагдлыг багасгах, усыг хэмнэлттэй ашиглах технологийн хувилбарыг судалж, тайланд тусгах; 4. Усны тухай хууль, тогтоомж болон бусад хууль тогтоомжоор хориглосон хязгаарласан бүсийн дэглэмийг зөрчихгүй байх талаар зөвлөмж боловсруулж тайланд хавсаргах; /Цооног ерөмдөх, худаг гаргах/				
	<b>Хөрсөн бүрхэвч</b>				
	Хөрсөн бүрхэвч эвдрэх, эсэх			Тийм	
	Хөрс бохирдуулах эсэх			Тийм	
	Хөрс доройтох, цөлжих эсэх			Тийм	
	1. Төслийн үйл ажиллагааны явцад хөрс, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнийг багасгах, арилгах, цөлжилт, хөрсний эвдрэлээс урьдчилан сэргийлэх арга зам, түүнд шаардагдах хөрөнгө зардлыг төлөвлөх;				

Төслийн байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ

	2. Хатуу, шингэн хог хаягдал, техник технологийн ашиглалтын явцад хөрс бохирдуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх;			
	<b>Ургамлан нөмрөг</b>			
	Ургамлан нөмрөг, ой мод өртөх эсэх		Тийм	Ургамлан нөмрөг өртөнө.
	Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлс өртөх, эсэх		Тийм	Нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлох
	1. Эдэлбэр газар, орчныг тохижуулах, ногоон байгууламж байгуулах талаар мэргэжлийн түвшний зөвлөмжийг шаардагдах зардлын хамт боловсруулж, тайланд тусгах; 2. Төслийн үйл ажиллагааны улмаас сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй биологийн төрөл зүйлийн бүрэлдэхүүнийг нарийвчилан тогтоож, хамгаалах арга замыг бодит цогц байдлаар шийдэх арга замыг судлан заах;			
	<b>Амьтны аймаг</b>			
	Зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах, эсэх		Тийм	
	Ховор, нэн ховор амьтан өртөх, эсэх		Тийм	
	Төсөл хэрэгжих нутаг орчмын амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг тооцож, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөх;			
Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	<b>Нутгийн оршин суугчид</b>			
	Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх, эсэх		Тийм	
	Нутгийн оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нөлөөлөлтэй, эсэх		Тийм	
	Нөлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар байгаа, эсэх		Тийм	
	Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх, эсэх		Тийм	
	Нарийвчилсан үнэлгээ хийх явцад тухайн нутагт оршин суугаа иргэдийн саналыг албан ёсоор авч, хорооны ИНХ-аар хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл, шийдвэрийг тайланд хавсаргах;			
	<b>Түүх, соёлын биет өв</b>			
	Сөрөг нөлөөлөлд өртөх түүх, соёлын үнэт зүйлс бий эсэх		Тийм	
	1. Үйл ажиллагааны явцад төсөл хэрэгжих орчны соёлт давхаргатай холбогдох археологи, палентологи, эртний түүхийн болон үнэт олдворууд зэргийн судалгааг нарийвчлан хийж холбогдох мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах; 2. Төсөл хэрэгжих нутаг орчмын түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээг холбогдох зардлын хамт тайланд тусгах;			
	<b>Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл</b>			
Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм			

	Төслийн бүх үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсэх эсэх	Тийм		
	Төслийн үйл ажиллагаа болон байгалийн гамшгаас үүдэн гарч болзошгүй ослын үнэлгээ хийж, ослоос сэргийлэх, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг тодорхойлж тайланд тусгана.			
<b>Нэгдсэн дүгнэлт:</b>				
<p>Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлээр “Иргэн П.Эрхэмбаяр” ХХКомпанийн Хөвсгөлийн байгалийн цогцолборт газрын “Ардгын аман”-д Аялал жуулчлалын баазын төсөлд Байгаль орчны сайдын “Аргачлал батлах тухай” 2014 оны А-117 дугаар тушаалын 2 ба 5 дугаар хавсралтын дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзлээ.</p>				
<b>Онцгойлон анхаарах зүйлс:</b>				
<ol style="list-style-type: none"> <li>1. БОАЖЯамны ТХНУГ-т төсөлөө танилцуулж, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг батлагдсан аргачлалын дагуу боловсруулах;</li> <li>2. Усны нөөцийн хүрэлцээ, усны нөөцийн асуудлыг холбогдох байгууллагаар дүгнэлт гаргуулан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд хавсаргах,</li> <li>3. Төсөл нь “Тусгай хамгаалалттай газар нутаг дахь, эко аялал жуулчлалын зориулалттай байр, сууц. Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 6426:2013 стандартын шаардлага хангаж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах;</li> <li>4. 3-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд БОНХСайдын 2014 оны А-117 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Үйлчилгээний салбарын төсөлд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх” шинэчилсэн аргачлалын дагуу Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг боловсруулах;</li> <li>5. Байгаль хамгааллын зорилго, байгалийн үнэт зүйлсийг хамгаалах үндсэн чиглэлтэй хэрхэн уялдаж байгаад үнэлэлт, дүгнэлт өгөх; Зөвлөмж боловсруулах;</li> <li>6. Төслөөс байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учруулж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тодорхойлж, үнэлэх;</li> <li>7. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгасан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг нарийвчлан гаргах; /Орчны бүсийг хамгаалах асуудлыг хамтад нь тусгах/</li> <li>8. Төслийн үйл ажиллагааны явцад ашиглаж байгаа болон унд ахуйд ашиглаж байгаа цэвэр усны хэрэглээний хэмжээг эх үүсвэртэй уялдуулан нарийвчилан тооцож, түүнээс гарах үйлдвэрлэлийн болон ахуйн бохир усыг, хатуу хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр зайлуулах аргыг нарийвчлан тодорхойлох;</li> <li>9. БОННУ-нд байгаль орчинд ээлтэй, олон улсын стандартад нийцсэн технологийг ашиглах талаар заавар зөвлөмжийг боловсруулах, агаарын бохирдолыг бууруулах зорилгоор сайжруулсан түлш хэрэглэх, ариун цэврийн байгууламж гэх мэт;</li> <li>10. Холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан барилга байгууламжийн батлагдсан зураг төслийг Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд хавсаргах;</li> <li>11. Гэрээгээр ашиглах газрын хариуцан хамгаалах орчныг тохижуулж, зүлэгжүүлэх, ногоон байгууламж байгуулах төсөл, боловсруулж хэрэгжүүлэх;</li> <li>12. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12 дугаар сарын 01-ний А/331 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулж, тодорхой шийдэл бүхий технологийг зөвлөмжөөр тайланд тусгах;</li> <li>13. Нарийвчилсан үнэлгээ хийх явцдаа тухайн газрыг хариуцан хамгаалж буй хамгаалалтын захиргаанд төслөө танилцуулж, санал авч тайланд хавсаргах ба төслөөс байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоон, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний талаар зөвлөж боловсруулан тайланд тусгах;</li> <li>14. Байгаль орчны хамгаалах тухай хуулийн 10<sup>1</sup> дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2 жил тутамд төслийн үйл ажиллагаанд хий асуудлыг холбогдох зардлын хамт тайланд тусгах;</li> </ol>				



15. Төслийн үйл ажиллагаатай холбогдуулж орон нутгийн засаг захиргааны болон байгаль орчны хяналтын байгууллагаас тавигдсан шаардлагуудыг биелүүлсэн эсэхэд холбогдох байгууллагаар дүгнэлт гаргуулан тайланд хавсаргах;
  16. 2012 оны 5 дугаар сард батлагдсан Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон Байгаль орчны сайдын 2010 оны 137 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал”-ын дагуу төслийн үйл ажиллагаанаас ургамал, хөрс, ус, амьтан, агаар орчинд учруулах хохирлыг байгалийн бүрэлдэл тус бүрээр тогтоож, улмаар тухайн газрыг эвдрэлд оруулснаар учирч болох хохирлыг урьдчилан тооцож нийлбэр үнэлгээ гарган төслийг хэрэгжүүлэх байгаль орчны хариуцлагын болон эдийн засгийн үндэслэлийг тодруулж дүгнэлт гаргах;
  17. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг 5 жилээр боловсруулж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төслийн хүчин чадал, төслийн үйл ажиллагааны өрнөлтийн байдалтай уялдуулан тооцож, төлөвлөх;
  18. Төслийн үйл ажиллагааны явцад баримтлах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ажиллагсадын эрүүл мэнд, ажлын байрны эрүүл ахуйн талаар зөвлөмж, дүгнэлт боловсруулах;
  19. Төсөл хэрэгжүүлж буй дүүргийн иргэд, орон нутгийн удирдлагын саналыг авч, төслөөс байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулж, тайланд тусгах;
  20. Төслийн хүрээнд баригдах дэд бүтцийн барилга, байгууламжийн зураг, төслийг нарийвчилсан үнэлгээний хүрээнд нэг бүрчлэн тодорхой болгож, барилгын ажлын явцад байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тогтоож, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг шаардагдах зардлын хамт тайланд тусгах;
  21. Байгаль орчны хамгаалах тухай хууль, Усны тухай хууль дүрэм журамуудын дагуу зөвлөмж, дүгнэлт боловсруулах;
  22. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2018 оны 04 сарын 05 өдрийн А/82/128 тоот тушаалд “Ус ашиглагч иргэн, аж ахуй нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах шаардлагатай”
- Төсөл хэрэгжих тухайн бүс нутагт ТХГНутгийн тухай хуулинд зааснаас өөр зориулалтаар газрыг ашиглахгүй байх;

**Бусад зүйлс:**

1. Төслийн үйл ажиллагаатай холбогдуулж орон нутгийн засаг захиргааны болон байгаль орчны хяналтын байгууллага, Хамгаалалтын захиргаанаас тавигдах нэмэлт шаардлагыг цаг тухай бүрт нь ханган биелүүлж байх;
2. Байгаль орчныг хамгаалах болон байгалийн нөөц баялгийг зохистой ашиглахтай холбогдсон хууль тогтоомжийг биелүүлэх талаар байгаль орчин, мэргэжлийн хяналтын байгууллагуудтай байнга хамтран ажиллах;
3. Нарийвчилсан үнэлгээний тайланд шүүмж хийлгэн дүгнэлт, шийдвэр гаргуулах асуудлыг ерөнхий үнэлгээгээр тогтоосон хугацаанд хэрэгжүүлэх;
4. Ерөнхий үнэлгээнд заасан чиглэл, нөхцөл, болзлоос өөр үйл ажиллагаа явуулах болон үйлдвэрлэлийг өргөтгөх шинэ тоног төхөөрөмж, технологи нэвтрүүлэх бүрт Ерөнхий үнэлгээнд хамрагдаж байх

Ерөнхий үнэлгээ хийсэн:

**Байгаль орчин, аялал жуулчлалын яамны шинжээч**

  
  
1119278520  
**Б.БАТБАЯР**

Ерөнхий үнэлгээний үр дүнг зөвшөөрсөн:  
**“Иргэн П.Эрхэмбаяр”**



**П.ЭРХЭМБАЯР**

## Хавсралт 5. Газрын кадастр

